Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын
2026 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн
1/1817 дугаар албан бичгийн хоёрдугаар хавсралт

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН
2026 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2026.06.22 Улаанбаатар хот

№	Зорилт /бодлогын үндэслэл/	Төсөл, арга хэмжээ	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		2026 онд шаардлагатай хөрөнгө		Үндсэн хариуцагч	Хамтран хариуцагч	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая.төг/	Хэрэгжилт	Үнэлгээ
			Суурь түвшин	Зорилтот түвшин	Хөрөнгийн хэмжээ /сая.төг/	Эх үүсвэр					
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 4.ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО											
Зорилго 4.12.Цахим засаглалын хөгжлийн индексийн үзүүлэлт сайжирсан байна.											
4.12.1	АХ-9.4.16 ШСБ-6.1 ЗГҮАХ - 3.3.7.5 , 4.3.1.3	4.12.1.1.Иргэний бүртгэл, үл хөдлөх хөрөнгө, төрийн өмчийн бүртгэл, газрын хэвлийн баялаг болон газар дээрх баялгийн бүртгэлийг "блокчейн" технологийг ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлж,	1	3	500,00	Улсын төсөв	ЦХИХХЯ	УБЕГ	-	Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүнийг дагалдан гарах Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, ХЗДХЯ-нд	30

		үйлчилгээнд нэвтрүүлэх								2026.06.03-ны өдрийн 1/4327 дугаар албан бичгээр тус тус хүргүүлэв. Хуулийн этгээдийн болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн системийг хөгжүүлэх, нэвтрүүлэх төслийн хэрэгжилтийн явцад ажлын цар хүрээ, шаардлагын өөрчлөлт, интеграцийн ажлын нэмэгдэл болон туршилт, хүлээн авах ажиллагааны нөхцөлөөс шалтгаалан гэрээний дагуу гүйцэтгэх ажлыг бүрэн, чанарын шаардлагад нийцүүлэн дуусгах шаардлага үүссэн тул УБЕГ-аас "Аствишн" ХХК системийн нэмэлт гэрээг 2026.04.09-ний өдөр байгуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд шаардлагатай интеграцийн үйлчилгээнүүдийг тодорхойлж, ГЗБГЗЗЕГ, МИК, ТатЕГ-тай байгууллага хоорондын интеграцийн шийдлүүдийг шинэ системд нэвтрүүлэх асуудлаар 7 хоног бүрийн Мягмар гарагт системийн хөгжүүлэлтийн явцтай танилцах хамтарсан уулзалт хийж хэвшсэн бөгөөд шийдвэрлэх шаардлагатай асуудлыг тухай бүр шийдвэрлэж байна. Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст 2026.06.05-ны өдрөөс системийг тестлэх ажлыг эхлүүлэн ажиллаж байна.	

										Үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн мэдээлэл төвлөрсөн мэдээллийн санд хадгалагдаж байгаа бөгөөд блокчейн технологийг ашигласнаар өмчлөх эрхийн бүртгэл, эрх шилжилт, барьцаа болон бусад өөрчлөлтийн мэдээллийг өөрчлөгдөшгүй хэлбэрээр хадгалах, бүртгэлийн ил тод байдал нэмэгдэх, хуурамч гэрчилгээ үйлдэх, бүртгэлийн мэдээллийг зөвшөөрөлгүй өөрчлөх, давхар бүртгэл үүсгэх зэрэг эрсдэлийг бууруулна. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн системд блокчейн технологийг туршилтын байдлаар нэвтрүүлэх, холбогдох эрх зүйн болон техникийн орчныг бүрдүүлэх, мэдээллийн системүүдийн уялдаа холбоог хангах чиглэлээр цаашид нарийвчилсан судалгаа, тооцоо хийхээр ажиллаж байна.	
4.12.2	ЗГҮАХ - 2.1.1.3 , 4.3.1.1 4.3.1.4	4.12.2.2.Төрийн үйлчилгээний нэгдсэн системд хиймэл оюун ухааныг нэвтрүүлэх	10	50	2,000.00	Улсын төсөв	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	Улсын бүртгэлийн ерөнхий газар	5.600,0	Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2026.01.13-ны өдрийн А/06 дугаар тушаалаар "Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хиймэл оюунд суурилсан технологийг нэвтрүүлэх хөтөлбөр"-ийг батлан, мөн ажлын даалгаврыг боловсруулан, баталсан. УБЕГ/20260102008 дугаартай "Улсын бүртгэлийн хиймэл	30

										оюунд суурилсан мэдээллийн технологийн тоног төхөөрөмж худалдан авах" тендерийн баримт бичгийг 2026.03.02-ны өдөр боловсруулж батлан, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-д байршуулж, тендерийн нээлтийг 2026.03.30-ны өдөр нээлттэйгээр зарлаж, "Грандмакс" ХХК шалгарч 2026.04.23-ны өдөр 2026/03, 2026/38 дугаартай гэрээ байгуулсан. Гэрээгээр тоног төхөөрөмж нийлүүлж, дараах программ хангамжийг хөгжүүлэхээр тусгасан. Үүнд 1. Иргэний өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх программ хангамж; 2. Ухаалаг чатбот *(мэдээллийн сан нь хуулиар нээлттэй байхаар тусгасан мэдээллийн иргэдэд хурдан шуурхай, цэгцтэй хүргэх программ хангамж)*; 3. Тайлангийн нэгдсэн программ хангамж; 4. Цахим гэрчилгээг олон хэлээр хөрвүүлэн авах боломжтой программ хангамж; 5. Цахимаар ирүүлсэн нотлох баримтыг шалгах программ хангамж; 6. Сонгогчийн ирц бүртгэлийн программ хангамж;	

										7. Иргэний бүртгэлийг системийг шинэчлэн хөгжүүлэх (Civil 4.0). Улсын бүртгэлийн байгууллагад хиймэл оюунд суурилсан технологийг нэвтрүүлэх төслийн хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2026.05.06-ны өдрийн А/95,96,97,98,99,100 дугаар тушаалаар чиг үүрэг тусдаа зургаан ажлын хэсэг байгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	
Биелэлтийн дундаж үнэлгээ											**30 хувь**

---oOo---